

ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2020 оны 06 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Чингис хаан Олон улсын нисэх буудлын Аж ахуй, хангамжийн хэлтсийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай ИНЕГ-ын даргын 2020 оны 05 дугаар сарын 26-ны өдөр баталсан 14/20 дугаар удирдамжийн хүрээнд тус хэлтсийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын Дотоод аудитын албаны ахлах аудитор Л.Жаргалсайхан, аудитор А.Мөнх-Эрдэнэ, Т.Саранчимэг, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ц.Цацрал нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 19-ний өдрийг дуустал хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Чингис хаан Олон улсын нисэх буудлын аж ахуй, хангамжийн хэлтсийн 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийг дуустал хугацааны үйл ажиллагаанд баримтлах дүрэм, журам, зааврын хэрэгжилт, дээд байгууллагаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, тус хэлтсийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт, дотоод хяналтын тогтолцоо, ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг хангаж байгаа эсэх зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгаж, холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Шалгах өдрийн байдлаарх бэлэн мөнгөний үлдэгдэл нягтлан бодох бүртгэлтэй зөрүүгүй тохирсон.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, худалдан авалтыг уламжлалт аргаар хэрэгжүүлсээр байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу урсгал зардлаар гүйцэтгэсэн худалдан авалтаа тайлагнаагүй.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан босго үнийг зөрчиж, худалдан авалтын журмыг буруу сонгосон.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан худалдан авах ажиллагааны чиглэлээр, эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн байх шаардлагыг хангасан ажилтны тоо хангалтгүйгээс цөөн тооны шаардлага хангасан ажилтан үнэлгээний хороо /ажлын хэсэг/-нд тогтмол томилогддог, мэргэжлийн чиглэлийн хүний нөөцийн хомсдолтой байдал нь худалдан авах ажиллагааны хараат бус байдал алдагдах, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл үүссэн.

Чингис хаан ОУНБ-ын гэрээ байгуулахад баримтлах журамд /ЧХОУНБ-УЖ-090:2016/ “Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн”-г санал авах албан тушаалтнаар тодорхойлсон боловч хуулийн хэлтсийн зүгээс гэрээг баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн талаар зааж өгөөгүй байна. Ингэснээр гэрээнд тавих хяналт суларсан байна.

Нягтлан бодох бүртгэлд бараа материалын зарлагыг тухай бүр хийдэггүйгээс бэлэн бүтээгдэхүүний эцсийн үлдэгдэл нягтлан бодох бүртгэлээс зөрүүтэй.

Нийтийн хоолны нярав нь ИНЕГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.3.3 дахь заалт “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм”, албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн үүргээ хангалттай биелүүлээгүйгээс илүүдэж, дутагдсан. Эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр бараа материалыг агуулахаас гаргасан байна.

Баоа материалын нярав нь Нягтлан бодох бүртгэлийн програмд конторын зориулалттай 5 нэр төрлийн бараа материалыг хэмжих нэгжийн дагуу тоо хэмжээг бүртгээгүй, 2 нэр төрлийн бараа материалын бүлэг ангиллыг буруу бүртгэсэн байна. Мөн эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр агуулахаас бараа материалыг гаргасан, бараа материалыг дутагдуулсан байна.

Галт зэвсгийн сумны хадгалалт хамгаалалт нь Монгол Улсын Галт зэвсгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасан ...Галт зэвсэг өмчлөгч хуулийн этгээд галт зэвсгийг зориулалтын төхөөрөмжилсөн өрөөнд, сумыг тусад нь түгжээтэй шүүгээ /сав/-нд хадгална... гэсэн заалтыг зөрчиж агуулахад зориулалтын бус тавиур дээр ил задгай хадгалагдаж байна.

Бараа, материалын хөдөлгөөн, үлдэгдлийн тоо хэмжээг агуулахын дэлгэрэнгүй бүртгэлийн дэвтэрт үнэн зөв, бүрэн гүйцэд хөтөлдөггүй, бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогыг чанартай хийдэггүй. Агуулахын эмх цэгц, хаягжилт хангалтгүй.

Үндсэн хөрөнгийн капиталжуулах зардлыг тайлант хугацааны гүйлгээний зардлаар бүртгэснээр хөрөнгийн өртөг буруу тооцогдох, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын бүртгэлээрх хяналт суларсан, үндсэн хөрөнгийн шинж чанартай эд зүйлийг зөвшөөрөлгүйгээр бэлтгэсэн.

Аж ахуй, хангамжийн хэлтсийн үйл ажиллагаанд ашиглах Veritech ERP цогц системийн захиалгын удирдлага, гэрээний удирдлага, худалдан авалтын удирдлага гэсэн 3 модулийг огт ашигладаггүй байна. Veritech ERP цогц системийн “Санхүүгийн цогц иж бүрэн програм”-ын ашиглалт хангалтгүй.

Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хугацаа хоцроож оруулдаг, буруу, дутуу мэдээлсэн, худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой мэдээллийг мэдээлээгүй. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг зөрчиж хүчингүй болсон анхан шатны бүртгэлийн маягтыг нягтлан бодох бүртгэлд ашиглаж байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар тус нисэх буудалд 16 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА